



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2018 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 01

Ховд

2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 11 цаг 40 минутад аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд хийж, хурлыг аймгийн Засаг даргын орлогч Ч.Уранчимэг удирдав.

Хуралд Засаг даргын орлогч Ч.Уранчимэг, Засаг даргын Тамгын газрын дарга Б.Ганболд, Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн дарга Б.Ганболд, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга М.Отгонханд, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Д.Солонго, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Гантөмөр, Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Гомбосүрэн, Жаргалант сумын Засаг дарга Ц.Ганданповрон оролцож, хурлын ирц 61.5 хувьтай байв.

Аймгийн Засаг дарга Д.Галсандондог өвчтэй, Засаг даргын орлогч Ш.Батсүх, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Баярсүх сумдад томилолтоор явсан, Хууль эрх зүйн хэлтсийн дарга Б.Мөнхбат, Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор Л.Галбадрах хуралтай байсан тул хуралд тус тус оролцсонгүй.

Ч.Уранчимэг-Зөвлөлийн хурлын ирц хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулж санал нэгтэй батлав.

ХЭЛЭЛЦСЭН нь:1. Улсын Их хурал, Засгийн газрын тогтоолоор батлагдсан Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцын тухай

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн Б.Гантөмөр оролцов.

Асуудал танилцуулсан: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Д.Солонго

0 2 00009

2...

СОНССОН нь: Засгийн газрын 2016 оны "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" 121 дүгээр тогтоолын хавсралтаар Монгол Улсын Засгийн газраас 2016-2020 онд шинээр боловсруулах 64, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх 14 үндэсний хөтөлбөрийн жагсаалт баталсан.

2017 оны жилийн эцсийн байдлаар дээрх хөтөлбөрүүдээс аймагт холбогдолтой хэрэгжүүлэх Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан 6 үндэсний хөтөлбөрийн 32 зорилт 81.3 хувь, Засгийн газрын тогтоолоор батлагдсан 28 үндэсний хөтөлбөрийн 131 зорилт 82.0 хувь, нийт 33 үндэсний хөтөлбөрийн 163 зорилт 82.0 хувьтай хэрэгжсэн дүнг, Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2017 оны жилийн эцсийн байдлаар графикаар, Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоолоор батлагдсан Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, Үндэсний хөтөлбөрийн биелэлтийг салбар тус бүрээр проектороор танилцуулав. Хяналт үнэлгээний дүнг хавсаргав.

Гишүүд хэлэлцсэн асуудлыг санал нэгтэй дэмжив.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Улсын Их хурал, Засгийн газрын тогтоолоор батлагдсан Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ, биелэлтийг хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, холбогдох яамдуудад хүргүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Д.Солонго, тус хэлтсийн мэргэжилтэн Б.Гантөмөр нарт үүрэг болгов.

Хэлэлцэх асуудал дуусаж, хурал мөн өдрийн 13 цаг 25 минутад дуусав.

ХУРАЛ УДИРДСАН:  
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  Ч.УРАНЧИМЭГ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:  
ТЗУХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН  М.ОТГОНХИШИГ

